

**ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН КОМИССЫН ШИЙДВЭР**

2021 оны 07 сарын 07 өдөр
№ 1

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн тухай

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 01 дүгээр хурлыг тусгай зөвшөөрлийн комиссын дарга бөгөөд Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга С.Мөнхтуяа даргалж, Аймгийн Засаг Даргын Тамгын Газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн О.Энхзул, Эрүүл Мэндийн Газрын Эмнэлгийн Тусламжийн Хэлтсийн дарга Б.Энхтуяа, Аймгийн Засаг Даргын Тамгын Газрын Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн Н.Оюун-Эрдэнэ, аймгийн ХХЭМБ-ын холбооны тэргүүн Ч.Очирбат нарын бүрэлдэхүүнтэйгээр 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Аймгийн ЭМГ-ын даргын өрөөнд хуралдав.

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын гишүүд тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусаж, ЭМС-ын тушаалын дагуу материалыг хуулийн хугацаанд бүрдүүлж хүсэлтээ ирүүлсэн 3 сувилал, 4 хувийн эмийн сан, 1 хувийн ахуйн мэрэгч, шавьж устгах, халдваргүйжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг ЭМБ, 1 сумын Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн үйл ажиллагаа, 2 сумын Эрүүл мэндийн төвийн эмийн эргэлтийн сан, 3 цэргийн ангийн эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой ЭМС-ын тушаалын дагуу бүрдүүлсэн баримт бичигт үндэслэн тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд сунгалт хийх, төсөл дэмжигдэж хяналтын чиг үүрэг бүхий байгууллагаар ажлын байрны үнэлгээ хийлгэсэн 2 байгууллагат шинээр тусгай зөвшөөрөл олгох эсэх, шинээр төсөл бичиж ирүүлсэн 4 аж ахуйн нэгжийн хүсэлт, өмнөх хурлаар албан бичиг хүргүүлэн нэмэлт материал бүрдүүлэн ирүүлсэн 2 ЭМБ-ын асуудал, Монгол шуудангаар холбогдох материал нь ирсэн "Ази фарма"ХХК-ны эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх төлсийг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Эрүүл мэндийн сайдын 2015 оны 298 тоот тушаалаар батлагдсан " Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах удирдамж"-ийн 2.1 дахь заалтыг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. ХҮЧИНТЭЙ ХУГАЦААГ СУНГАСАН АЖ АХУЙН НЭГЖҮҮД:

| № | ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУД | СУНГАЛТ ХИЙСЭН ЖИЛ |
|----|---|--------------------|
| 1 | "Заамар чансаа"эмийн сан | 3 жил |
| 2 | "Далантүрүү" эмийн сан | 3 жил |
| 3 | "Сод үжин" эмийн сан | 5 жил |
| 4 | "Бүрэн арвижих дэлгэрэх" эмийн сан | 5 жил |
| 5 | Баянчандмань СЭМТөв. ЭЭС | 5 жил |
| 6 | Эрдэнэсант сумын ЭМТөв. ЭЭС | 5 жил |
| 7 | "Замтын булаг" сувилал | 5 жил |
| 8 | "Мөнхжин " сувилал | 5 жил |
| 9 | "Загалын овоо "ХХК, Дарцаг сувилал | 3 жил |
| 10 | "СОСУ" ХХК | 5 жил |
| 11 | Эрдэнэсант сумын ЭМТөвийн эмнэлгийн үйл ажиллагаа | 5 жил |
| 12 | Зэвсэгт хүчний 119 ангийн эмнэлэг | 5 жил |
| 13 | Зэвсэгт хүчний 311 ангийн эмнэлэг | 5 жил |
| 14 | Зэвсэгт хүчний 016 ангийн эмнэлэг | 5 жил |

2. АЛБАН БИЧИГ ХҮРГҮҮЛЭХ АЖ АХУЙН НЭГЖ:

- Шинээр төсөл бичиж ирүүлсэн “Тод ариусгал” ХХК, ахуйн шавж мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа явуулах төслийг аймгийн эрүүл мэндийн чиглэлээр ТЗОК-ын гишүүд 100%-ийн саналаар дэмжихгүй шийдвэр гарсан тул ЭМГ-ын даргын албан тоотыг хүргүүлж хүний нөөц, ажлын байрыг тодорхой болгох шийдвэр хүргүүлэх.

3. ТӨСӨЛ ДЭМЖИГДСЭН АЖ АХУЙ НЭГЖҮҮД:

- Шинээр төсөл бичиж ирүүлсэн “Өрнийн бэрс” ХХК-ны “BETTER MIND” сэтгэл заслын эмнэлгийн төслийг аймгийн эрүүл мэндийн чиглэлээр ТЗОК-ын гишүүд 100%-ийн саналаар дэмжив. ЭМГ-ын даргын дэмжсэн албан тоотыг хүргэх шийдвэр гарсан.
- Шинээр төсөл бичиж ирүүлсэн “ДЭБИ” ХХК-ны эмийн сангийн төслийг аймгийн эрүүл мэндийн чиглэлээр ТЗОК-ын гишүүд 100%-ийн саналаар дэмжив. ЭМГ-ын даргын дэмжсэн албан тоотыг хүргэх шийдвэр гарсан.
- Шинээр төсөл бичиж ирүүлсэн “Түм гэрэлтэх” ХХК, эмийн сангийн үйл ажиллагаа явуулах төслийг аймгийн эрүүл мэндийн чиглэлээр ТЗОК-ын гишүүд 80%-ийн саналаар дэмжих шийдвэр гарсан.
- Шинээр төсөл бичиж ирүүлсэн “Ази фарма” ХХК, эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх төслийг аймгийн эрүүл мэндийн чиглэлээр ТЗОК-ын гишүүд 80%-ийн саналаар дэмжих шийдвэр гарсан.

4. ШИНЭЭР ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙ НЭГЖҮҮД:

- Мөнгөнморьт суманд байрлаж эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх 1411011208 улсын бүртгэлийн дугаар бүхий “Оюут ян” ХХК-д ТЗОК-ын гишүүд 100%-ийн саналаар тусгай зөвшөөрөл шинээр олгохоор шийдвэр гаргасан. Аймгийн МХГ-ын улсын байцаагчийн үнэлсэн шалгуур үзүүлэлтээр шаардлага хангаагүй заалтуудыг биелүүлэх хугацаатай үүргийг албан тоотоор хүргүүлэх.
- Зуунмод суманд байрлаж, эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх 1411001125 улсын бүртгэлийн дугаар бүхий “Цагаан-Уул” ХХК-д ТЗОК-ын гишүүд 100%-ийн саналаар тусгай зөвшөөрөл шинээр олгохоор шийдвэр гаргасан. Аймгийн МХГ-ын улсын байцаагчийн үнэлсэн шалгуур үзүүлэлтээр шаардлага хангаагүй заалтуудыг биелүүлэх хугацаатай үүргийг албан тоотоор хүргүүлэх.

5. Дахин хурлаар оруулах ЭМБ:

- Өмнөх хурлаар нэмэлт материал бүрдүүлж ирүүлэх албан бичиг хүргүүлсэн “Монгол эм импекс концерн” ХХК-ны эмийн сангийн нэмэлт мэдээллийг танилцаж үзээд тодруулга ажлын алба дахин хийж дараагийн хурлаар оруулах

КОМИССЫН ДАРГА

С.МӨНХТУЯА

